



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/483

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211, 2020 оны "Зөвлөмж батлах тухай" 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Наран багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй "Хан-Алтай ресурс" ХХК-ийн уул уурхайн төслийн хүдэр боловсруулах үйлдвэрийн урвалжийн агуулахын барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандахүү	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Ц.Амарсанаа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Ш.Мөнхцэцэг	(Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны улсын хяналтын байцаагч)
	Д.Отгонжаргал	(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Б.Батбилэг	(Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)

